<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>961,822,100.00</b>	<b>958,743,626.43</b>
320001	Орон нутгийн төсвөөс	859,114,900.00	856,036,476.43
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	102,707,200.00	102,707,150.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>336,509,200.00</b>	<b>83,478,082.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	158,576,400.00	83,478,082.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	177,932,800.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	89,973,630.19
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	108,824,334.27
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>76</b>	<b>52</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>
610001	Төсвийн байгууллага	2	2
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>37</b>	<b>25</b>
620001	Удирдах ажилтан	7	7
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14
620003	Үйлчлэх ажилтан	16	4
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>37</b>	<b>25</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	20	8
650010	Гэрээт ажилтан	0	0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>196,253,669.44</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>196,253,669.44</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>193,603,852.00</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>193,603,852.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	193,603,852.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,649,817.44</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,649,817.44</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	169,791.44
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,480,026.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>196,083,878.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>196,083,878.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,000,000.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	178,819,252.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,361,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,903,626.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-169,791.44</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	169,791.44
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бугат сумын Засаг даргын тамгын газар нь Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд, Төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, олон улсын байгууллагаас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зөв зохистой ашиглан хэрэгжүүлэх, иргэдийн оролцоо ил тод байдлыг хангах, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хүн амаа өсгөх, сум орон нутгаа хөгжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн тодорхой үр дүнд хүрэх зорилт тавин ажиллажээ.

ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Сумын Засаг даргын Тамгын газар нь сумын ИТХ, Засаг даргын үйл ажиллагааны зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн зөвлөгөө дэмжлэгээр хангах

- Төрийн үйлчилгээг чанар хүртээмжтэй шуурхай хүргэх
- Нутгийн захиргааны байгууллагуудыг бодлогоор дэмжих, эрх зүйн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангах
- Шийдвэрийн биелэлтэд хяналт шинжилгээ хийж, ололт амжилтыг урамшуулах, алдаа дутагдлыг засаж залруулах, сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг арга зүйн зөвлөмжөөр ханган төрийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, орон тоо байхгүй аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт дотоод аудитын алба гүйцэтгэж байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,941,824.7 төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	179,070.00	164,783.80	-14,286.20
Авлага	301,524.20	241,158.50	-60,365.70
Бараа материал	380,716.80	81,422.20	-299,294.60
Үндсэн хөрөнгө	4,922,011.10	1,354,132.90	-
Нийт хөрөнгө	<b>5,783,322.10</b>	<b>1,841,497.40</b>	3,941,824.70
Өр төлбөр	6278.8	3583.5	-2,695.30
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5777043.3	1837913.9	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<b>5783322.1</b>	<b>1841497.4</b>	3,941,824.70

Эх сурвалж: Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 179,070.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 164,783.8 мянган төгрөг болж өмнөх оноос 14,286.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралт
Хоршоо хөгжүүлэх сан	60,195.80	48,348.90	-11,846.90
Төрийн сангийн харилцах	88,926.60	55,959.50	-32,967.10
ОНХсан	5,707.20	48,218.80	42,511.60
ЖДҮДСан	1,725.20	2,394.70	669.50
ЭМТ	11,289.30	0	-11,289.30
БХСан	11225.9	9861.9	-1,364.00
Дүн	179,070.00	164,783.80	-14,286.20

Эх сурвалж: Могод сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 164783.8 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны 55959.5 мянган төгрөг нь орон нутгийн орлогын давсан

орлого, орон нутгийн хөгжлийн санд 48218.8 мянган төгрөг нь малын хөлийн татвар болон хэрэгжээгүй төсөл арга хэмжээний үлдэгдэл байна.

Төсөл сангуудын үлдэгдэлд сум хөгжүүлэх сангийн 48348.9, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан 2394.7, байгаль хамгаалах санд 9861.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тус тус төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансны эхний үлдэгдэл 301,524.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 241,158.5 мянган төгрөг болж, 60365.6 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт № 3 Авлагын үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	13027.9	3,697.20	-9,330.70
Хүмүүсээс авах авлага	219942.4	232,912.60	12,970.20
Зээлийн авлага	1218.9	519.4	-699.50
Ажиллагчидтай холбогдсон авлага	4502.1	4029.3	-472.80
Төлбөртэй үйлчилгээний авлага	62832.8	0	-62,832.80
<b>Дүн</b>	<b>301,524.10</b>	<b>241,158.50</b>	<b>(60,365.60)</b>

Эх сурвалж: бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Байгууллагаас авах авлагад хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн 155468.2, мянган төгрөг, ЖДҮД сангийн 55881.8, орон нутгийн орлогын 2082.0, орон нутгийн хөгжлийн сангийн 20,000.0, ЗДТГ-ын 7726.5 мянган төгрөгийн байна.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ эхний үлдэгдэл 380716.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 81,422.2 мянган төгрөг болж, 299.294.5 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	61,291.50	0	-61,291.50
Бичиг хэрэг	3,509.80	2,720.60	-789.20
Аж ахуйн материал	266,945.40	54,853.60	-212,091.80
Сэлбэг хэрэгсэл	3,521.80	1528	-1,993.80
Түлш, шатах тослох материал	5,651.50	0	-5,651.50
Барилгын засвар			0.00
Хүнсний материал	3,565.30	0	-3,565.30
Бусад хангамж	11,711.40	0.00	-11,711.40
Нөөцүн бараа			0.00

Мал амьтад	24,520.00	22320	-2,200.00
<b>Дүн</b>	<b>380,716.70</b>	<b>81,422.20</b>	<b>-299,294.50</b>

Эх сурвалж: Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 90558.9 , хандив тусламжаар 7000.0 төгрөгийн бараа материалыг авч, тайлант онд 90389.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулж, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр тусгай шилжүүлгийн байгууллагын 304263.8 төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 2200.0 мянган төгрөгийн малыг акталж устгаж 81,422.2 үлдэгдэлтэй байна.

Нийт бараа материалын үлдэгдлийг байгууллагаар харуулбал

Хүснэгт № 5 Бараа материалын үлдэгдэл байгууллагаар

/мян.төгрөг/

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1	ИТХ	3,712.70	6,306.20	
2	ЗДТГ	72,740.30	75,115.90	
3	Хүн эмнэлэг	109,748.20	0	
4	Цэцэрлэг	45,484.90	0.00	
5	Сургууль	133,172.10	0	
6	Соёлын төв	15,858.50	0	
	<b>Дүн</b>	<b>380,716.70</b>	<b>81,422.10</b>	<b>0.00</b>

Нийт бараа материалын данснаас бүтцийн өөрчлөлтөөр Соёлын төв 15858.5, Сургууль 133172.1, цэцэрлэг 45484.9, ЭМТ 109748.2 нийт 304263.8 мянган төгрөгийг хөрөнгийг шилжүүлжээ.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 5,948,527.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 2,054,438.0 мянган төгрөг болж, 3,894,089.3 мянган төгрөгөөр буурсан байна.~~

Хүснэгт № 6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мян.төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1	Барилга байгууламж	4,429,102.80	1,079,845.00	-3,349,257.80
2	Авто тээврийн хэрэгсэл	319,867.40	188,051.10	-131,816.30
3	Машин тоног төхөөрөмж	397,303.40	157,504.10	-239,799.30
4	Тавилга, аж ахуйн эд хогшил	134,099.70	37,555.50	-96,544.20
5	Түүх соёлын дурсгал	16,280.00	16,280.00	0.00
6	Ном	31,008.30	934.6	-30,073.70
7	Бусад үндсэн хөрөнгө	396,814.20	438280.2	41,466.00
8	Программ хангамж	8,945.50	3,495.50	-5,450.00
9	Бусад биет бус хөрөнгө	215,106.00	132,492.00	-82,614.00

	<b>Дүн</b>	<b>5,948,527.30</b>	<b>2,054,438.00</b>	<b>-3,894,089.30</b>
--	------------	---------------------	---------------------	----------------------

Эх сурвалж: Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 27,120.1, хандив тусламжаар 101,719.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, бүтцийн өөрчлөлтөөр тусгай зориулалтын шилжүүлгийн 4051882.1 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлжээ.

Хүснэгт № 7 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар

/МЯН.ТӨГРӨГ/

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1	ИТХ	12,494.30	14779.3	2,285.00
2	ЗДТГ	1,884,150.90	2,039,658.70	155,507.80
3	Хүн эмнэлэг	803,113.60		-803,113.60
4	Цэцэрлэг	466,955.40		-466,955.40
5	Сургууль	2,698,622.50		-2,698,622.50
6	Соёлын төв	83,190.60		-83,190.60
	<b>Дүн</b>	<b>5,948,527.30</b>	<b>2,054,438.00</b>	<b>-3,894,089.30</b>

Эх сурвалж: Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны бүтцийн өөрчлөлтөөр хасагдсан байгууллагыг авч үзвэл Соёлын төв 83,190.6, Сургууль 2,698,622.5, Цэцэрлэг 466,955.4, ЭМТ-ийн 803,113.6 мянган төгрөгийг хөрөнгийг шилжүүлжээ.

### 3.5.7 Өр төлбөр

Тайлан онд өр төлбөрийн дансны эхний үлдэгдэл 6278.8, эцсийн үлдэгдэл 3583.5 ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн~~ мянган төгрөг болж өмнөх оноос 2695.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/МЯН.ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	734.7		-734.7
Бараа үйлчилгээний өглөг	1467.8		-1467.8
Байгууллагаас авах авлага	40001.2	3583.5	
Хүмүүст өгөх өлөг	75.0		-75.0
<b>Дүн</b>	<b>6278.8</b>	<b>3583.5</b>	<b>2695.3</b>

Эх сурвалж: Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эхний үлэгдэл 6278.8 мянган төгрөгөөс 2695.3 мянган төгрөгийн өглөг барагдуулж орон нутгийн хөгжлийн сангийн 2416.0, сум хөгжүүлэх 1167.4 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,693,435.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,837,913.9 мянган төгрөг болж, 3,855,521.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 9 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

/МЯН.ТӨГРӨГ/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+, бууралт /-/</u>
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	1,484,959.40	672,610.80	-812,348.60
<u>Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/</u>			0.00
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	3,242,037.10	717,493.20	-2,524,543.90
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	1,050,046.80	447,809.90	-602,236.90
<u>Бодлогын өөрчлөлт алдааны залруулга</u>	-83,607.60		83,607.60
<b>Дүн</b>	<b>5,693,435.70</b>	<b>1,837,913.90</b>	<b>-3,855,521.80</b>

Эх сурвалж: Бугат сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,693,435.7 мянган төгрөг эцсийн үлдэгдэл 1,837,913.9 болж 3,855,521.8 мянган төгрөгөөр буурсан нь тусгай шилжүүлгийн байгууллагууд орон нутгийн төсвөөс хасагдсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн орлогоос 309,427.4, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 549,687.5, ОНХС-аас 102707.2, төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогоос 158,576.4, урьд оны үлдэгдлээс 177932.8 мянган төгрөг нийт зарлагыг 1,298,331.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн орлогоос 309,427.4, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 549,687.5, ОНХС-аас 102707.2, төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогоос 158,576.4, урьд оны үлдэгдлээс 177932.8 мянган төгрөг нийт зарлагыг 1,298,331.3 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 282181.5, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 540,887.5, ОНХС-аас 102707.2, төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогоос 83478.1 нийт 1042221.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1012251.5 мянган төгрөг буюу 77.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвөөс цалин хөлсийг 39332.3, тогтмол зардлыг 17724.9, бараа үйлчилгээний зардлыг 20628.8, хөрөнгийг зардал буюу ОНХС-гаас 74981.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Ерөнхий боловсрол	174,991.10	174,441.60	549.50	99.7
2	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	77,776.30	77,131.50	644.80	99.2
3	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	457,251.70	398,371.00	58,880.70	87.1
4	Соёл урлаг	22,018.80	19,635.40	2,383.40	89.2

5	Сургуулийн өмнөх боловсрол	45,347.90	44,443.10	904.80	98.0
6	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	55,096.80	54,957.60	139.20	99.7
7	Сумын ОНХС	227,673.30	152,691.90	74,981.40	67.1
8	Сум хөгжүүлэх сан	198,391.60	81,087.50	117,304.10	40.9
	БХ сан	30,000.00	9,492.00	20,508.00	31.6
9	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	9,783.80		9,783.80	0.0
	Нийт дүн	1,298,331.30	1,012,251.60	286,079.70	78.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар сумын ЗДТГ-т нийгмийн хариуцлагын хүрээнд 2 аж ахуйн нэгж 4,000.08 мянган төгрөгийн хандив, аймгийн ЗДТГ, авто замын сангаас хатуу хучилттай авто зам 77,270.3, чулуутын даваа засах 60,000.0, хожуул төсөлд 15,000.0, цахилгаан хангамжийг эх үүсвэрийн дэмжлэг 10,000.0 зэрэг нийт 178519.2, дээд шатны төсөв захирагчаас малын тооллогын зардалд 3361.0, өөрийн үйл ажиллагааны хүрээнд нэмэлт орлогоор Орхон аймгийн баяр наадмын морь барианы хураамжид 8000.0 мянган төгрөгийн нийт 194360.3 мянган төгрөгийн орлого нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах 2 холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,298,331.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 19,474.9 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага арга хэмжээ авч ажилласан байна.

цалин хөлсийг 39332.3, тогтмол зардлыг 17724.9, бараа үйлчилгээний зардлыг 20628.8, хөрөнгийг зардал буюу ОНХС-гаас 74981.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэлт үүссэн байна.

## **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

### **4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд 23 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"; 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"; гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## **4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

### **4.7.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитыг хийгээгүй.

### **4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар малын тоо толгойн албан татварын дутуу 20645.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/269 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

*Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	20645.6	1	10643.7	100
Албан шаардлага	0	0	0	0	
Зөвлөмж	4		4		100
<b>Нийт дүн</b>					

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын орон нутгийн орлогод 16 нэр төрлийн орлогыг 313127.4 мянган төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 287621.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж нийт дүнгээрээ 25505.5 мянган төгрөгөөр тасалсан байна. Орон нутгийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 42,099.7 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 16,594.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 25505.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Сумын ИТХ-ын 2021 оны 03/01 дүгээр тогтоолоор малын тоо толгойн албан татварыг тогтоосон, 2021 оны жилийн эцсийн малын тоо толгойгоор тооцож үзэхэд 71594.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр байгаа боловч орон нутгийн орлогод 55,000.0 мянган төгрөгийг төлөвлөн баталсан, дутуу төлөвлөсөн 16594.2 мянган төгрөгийн татварыг дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Орлогын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Сумын орон нутгийн орлогод 16 нэр төрлийн орлогыг 313,127.4 мянган төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 287,621.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж нийт дүнгээрээ 25,505.5 мянган төгрөгөөр тасалсан байна. Үүнийг авч үзвэл газрын төлбөр 18931.8, малын тоо толгойн албан татварыг 16762.5, бусад орлогыг 5000.0, хөрөнгийн орлогыг 3812.1, үл хөдлөх хөрөнгийг орлогыг 760.5 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Орон нутгийн орлогыг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслэн бүрэн төлөвлөж, биелэлтийг хангаж байх.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 2. Шилэн данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант онд 23 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"; 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"; гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мян. төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бугат ЗДТГ	1	8181.2			1	8181.2	1	8181.2				
Бугат сумын ИТХ	1	450.9			1	450.9	1	450.9				
Дүн												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мян

төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	4	5973.8	2	1568.0	1	4,405.8	1					
Бугат сумын ИТХ	2	541.9	2	541.9								
ОНХС	1	31000.0					1	31,000.0				
Дүн	7	37515.7	4	2109.9	1	4405.8	2	31000.0				